



## “ОРОН НУТАГТАА ОРУУЛАХ БИДНИЙ ХУВЬ НЭМЭР” УРАЛДААНЫ УДИРДАМЖ

2024.03.15

Мандалговь хот

### НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Сайнцагаан суманд жилд дунджаар 80.000 тн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэг рүү шилжүүлж булж устгаж байна. Энэ хог хаягдлын 40-50 хувийг буюу 45.000 тн хог хаягдлыг дахин боловсруулах, дахин ашиглах боломжтой байдаг. Гэвч одоогийн байдлаар 2024 онд нийт 78.1 тн буюу нийт хог хаягдлын 0.09%-ийг л дахин боловсруулах үйлдвэрт тушаасан байна.

Уралдааныг зохион байгуулснаар Хог хаягдлын тухай хууль, Дундговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 6.4.1 дэх заалт, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.2 дахь заалт, Сайнцагаан сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1 дэх заалтуудыг хэрэгжүүлж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх дахивар нөөцийн хэмжээг нэмэгдүүлнэ.

### ХОЁР. ЗОРИЛГО

Хог хаягдлаас үүдэлтэй хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хог хаягдлын хэмжээг бууруулах, сурагчдад хог хаягдлаа ангилан ялгах дадал хэвшил суулгах, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор хамгийн их дахивар нөөц цуглуулж тушаасан анги, сургуулийг тодруулж урамшуулна.

### ГУРАВ. ХАМРАХ ХҮРЭЭ

- ✓ Сайнцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулиуд
- ✓ Политехник коллеж
- ✓ Бусад сумдын Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид оролцож болно.

### ДӨРӨВ. ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

- ✓ Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газар
- ✓ Байгаль орчин, аялал жуулчлалын газар
- ✓ Мандалын гэгээ хот тохижуулах газар
- ✓ Баялаг төв

## ТАВ. ХУГАЦАА

2024 оны 03 дугаар сарын 18-ний өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийг дуустал

## ЗУРГАА. УРАЛДААНД ОРОЛЦОГЧДОД ТАВИГДАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

### 1-7-р ангийн сурагчдын дунд

1. Баялаг төвөөс гаргасан жагсаалтын дагуу шаардлага хангасан дахивар бүтээгдэхүүнийг цуглуулж, тухайн сургуулийн хуваарьт өдөр баялаг төвд тушааж, баримт авах /Дахиварт тавигдах шаардлага хавсралт1, Дахиврын жагсаалт хавсралт2/ Хамгийн их дахивар цуглуулсан ангийг тодруулах

### 8-12-р ангийн сурагчдын дунд

1. Баялаг төвөөс гаргасан жагсаалтын дагуу шаардлага хангасан дахивар бүтээгдэхүүнийг цуглуулж, тухайн сургуулийн хуваарьт өдөр баялаг төвд тушааж, баримт авах /Дахиварт тавигдах шаардлага хавсралт1, Дахиврын жагсаалт хавсралт2/ Хамгийн их дахивар цуглуулсан ангийг тодруулах
2. Уралдаан зохион байгуулагдах хугацаанд хог хаягдлын хор уршиг, хог хаягдал ангилан ялгах талаар 2 минут хүртэлх богино хэмжээний геел бичлэг хийж Баялаг төвийн пэйж хуудас руу илгээнэ. Баялаг төвийн пэйж хуудсанд бичлэг тавигдсанаас хойш хамгийн их лайк, шэйр цуглуулсан ангийг тодруулна.
3. Сургуулийн ойр орчим, гэр хорооллын гудамж, тоглоомын талбай зэрэг нийтийн эзэмшлийн талбайг сонгон их цэвэрлэгээ хийж өмнө ба дараа зураг авч баталгаажуулан @Баялаг төв пэйж хуудас руу илгээх /300 кг-аас дээш хэмжээтэй, овор хэмжээ ихтэй хог хаягдал цэвэрлэсэн тохиолдолд Мандалын гэгээ хот тохижуулах газар 88076529 утсаар холбогдон хогоо ачуулах боломжтой/
4. Дээрх 3 үнэлгээнээс үндэслэн хамгийн өндөр оноотой ангийг шалгаруулж байр эзлүүлнэ.

### Сургуулиудын дунд

Уралдааны мэдээллийг сургуулийн сурагчдад түгээж хамгийн олон анги, хамт олныг оролцуулсан, оролцсон ангиуд шалгуурыг бүрэн хангасан байгаа байдал зэргийг харгалзан шилдэг 1 сургуулийг шалгаруулна.

## ДОЛОО. УРАЛДААНЫ ШАЛГАРУУЛАЛТ

- Уралдаанд оролцсон ангийн оролцогчдод тавигдах шаардлагыг бүрэн хангасан эсэх
- Баялаг төвд тушаасан дахиврын хэмжээ

- Цахим хандалт /Like-1 оноо, share-2 оноо/
- Хамгийн олон анги оролцож, хамгийн их дахивар цуглуулсан сургууль
- Идэвх санаачилга зэргийг харгалзан үзэж зохион байгуулагч байгууллагуудын ажлын хэсэг 05 сарын 16-18-ны өдрүүдэд шалгаруулна.

## НАЙМ. ШАГНАЛЫН САН

1. 1 дүгээр байр 500,000 төгрөг /Ангилал тус бүрт 1 байр/
2. 2 дугаар байр 300,000 төгрөг /Ангилал тус бүрт 1 байр/
3. 3 дугаар байр 200,000 төгрөг /Ангилал тус бүрт 1 байр/
4. Шилдэг сургууль 1,000,000 төгрөг /1/

## ЕС. ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН

- Уралдаанд оролцож байгаа сурагчид болон тэдний гэр бүл хог хаягдлын талаар ойлголттой болно.
- Цахимаар хог хаягдлын хор уршиг болон ангилалтын талаар бичлэг явснаар олон нийтийн хог хаягдал болон түүний ангиллын талаарх ойлголт нэмэгдэнэ.
- Уралдааны үр дүнд тодорхой хэмжээний хог хаягдлыг дахин боловсруулах боломжтой болно.

Удирдамжтай холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл авах утас: 86911900, БОАЖГ мэргэжилтэн А.Ганцэцэг

### “ОРОН НУТАГТАА ОРУУЛАХ МИНИЙ ХУВЬ НЭМЭР”

#### УРАЛДААНЫ ТӨСӨВ

| № | Нэр             | Хэмжих нэгж | Тоо | Үнэ       | Нийт (төг)       |
|---|-----------------|-------------|-----|-----------|------------------|
| 1 | 1-р байр шагнал | ш           | 2   | 500,000   | 1,000,000        |
| 2 | 2-р байр шагнал | ш           | 2   | 300,000   | 600,000          |
| 3 | 3-р байр шагнал | ш           | 2   | 200,000   | 400,000          |
| 4 | Шилдэг сургууль | ш           | 1   | 1,000,000 | 1,000,000        |
|   | Нийт            |             |     |           | <b>3,000,000</b> |

САЙНЦАГААН СУМЫН ЗДТГ, БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

БАЯЛАГ ТӨВ



## ДАХИВАРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА

**PET** Хуванцар /Энэ төрөлд ундаа усны сав багтана. Наадах цаадах нь гэрэлтдэг буюу тунгалаг байна. Саван дээрээ PET гэсэн тэмдэглээтэй сав. /

- Ямар ч шингэний үлдэгдэлгүй, хог хаягдлыг дотор нь хийгээгүй байна
- Дотор нь сүү, айраг, тараг гэж мэт цагаан идээ хийсэн сав нь дахин боловсруулагддаггүй учир тийм сав авахгүй
- Савны тагийг авч, савыг овор хэмжээг багасган, навшийлгасан байна.
- Тагийг HDPE төрөлд оруулан ангилна.

**HDPE** хуванцар /Энэ төрөлд ихэвчлэн цэвэрлэгээний бодис, саван, шампунь, тос маслоны сав орно. Саван дээрээ HDPE гээд, гурвалжин дотор 2 гэсэн тэмдэглэгээтэй байна./

- Ямар ч шингэний үлдэгдэлгүй, хог хаягдал дотор нь хийгээгүй байна.
- Ундаа усны савны таг нь энэ төрөлд багтана.

**PP** хуванцар /Энэ төрөлд ихэвчлэн гоо сайхны сав багтдаг/

- Ямар ч шингэний үлдэгдэлгүй, хог хаягдал дотор нь хийгээгүй байна.

**Зузаан гялгар уут** /Энэ төрөлд ундаа усны гадуур багцалдаг гялгар уут орно./

- Гялгар уут нь нороогүй, шороо болоогүй байна.
- Дотор нь хог хийгээгүй байна.

**Архи, пивоны шил** /Шилний нэр төрлийг хавсралт 2-оос харна уу/

- Архины шил нь хагарч, цуураагүй бүтэн байна
- Шороо, дотроо шингэнгүй байна
- Үйсэн бөглөөтэй шилнүүдийн бөглөөг авсан байна
- Шил тус бүрийг ижил грамм, ижил нэршилээр ангилж савласан байна.
- GEM архины шилнүүд нь огт зурагдаагүй, угааж цэвэрлэсэн маш цэвэр байна. Шилний сүүн өнгө, алтлаг өнгө арилаагүй байна.

**Огурцы салатны шил** /Шилний төрлийг хавсралт 2-оос харна уу/

- Шил нь хагарч, цуураагүй бүтэн байна
- Шороо болоогүй байна
- Дотроо шингэнгүй байна
- Угааж, цэвэрлэсэн байна
- Тагтай байна
- Шил тус бүрийг ижил граммаар нь савласан байна

**Лааз** /Соронзонд наалддаггүй, хөнгөн цагаан лааз байна/

- Ямар ч шингэний үлдэгдэлгүй байна
- Лаазны овор хэмжээг багасгаж, навшийлгасан байна.

**Өнгөт металл**

- Зэс, гууль
- Хөнгөн цагаан, хайлш
- Тугалга
- Хуучин аккумулятор
- Хабрид машины хроп зэргийг төрөл бүрээр ангилж, савласан байна.

## АВАХ ДАХИВАРЫН ЖАГСААЛТ

1. Ундаа усны сав буюу PET хуванцар
2. Зөөлөн хуванцар буюу HDPE хуванцар
3. Зузаан гялгар уут буюу багцлагч уут
4. Лааз
5. АПУ-н архины шил
6. АПУ-н пивоны шил
7. GEM-ын архины шил
8. Огурцы, салатны шил
9. Хужирт усны шил

| Дахиварын төрөл | Хэмжээ        |
|-----------------|---------------|
| Экс             | 0.35          |
| Экс             | 0.5           |
| Экс             | 0.75          |
| Хараа           | 0.35          |
| Хараа           | 0.5           |
| Хараа           | 0.75          |
| Нийслэл         | 0.45          |
| Калтенберг      | 0.45          |
| Сэрүүн          | 0.45          |
| Алтанговь       | 0.33          |
| Боргио          | 0.5           |
| Сэнгүр          | 0.5           |
| Тайгер          | 0.5           |
| Тайгер          | 0.33          |
| Соёрхол         | 0.33-аас дээш |
| Шар чингис      |               |
| Цагаан          |               |
| Моду            |               |
| Хужирт ус       | 0.33          |
| Хужирт ус       | 0.7           |
| Варений шил     | 550гр         |
| Варений шил     | 720гр, 920гр  |